

# БӨХӨГ ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн мэндийг хүргэж хуралд нь амжилт хүсье.

2017-2018 оны Бөхөг ХК-ийн үйл ажиллагааны тайланг та бүхэнд танилцуулъя.

2018 оны ерөнхий төлөвлөгөөнд 5 чиглэлээр 40 ажил тусгагдсан.

## I. Байгууллагын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр

1.1 Шувууны аж ахуйн олон улсын стандартыг судлан Бөхөг ХК-ийн одоогийн нөхцөл байдалд дүгнэлт хийн зохион байгуулалтын өөрчлөх саналыг ТУЗ-д танилцуулсан. Энэ дагуу судалгаа шинжилгээний ажлыг хийх, зорилгоор АНУ-ын Атланта хотод зохион байгуулагдсан дэлхийн шувууны аж ахуй, үйлдвэрлэлийн үзэсгэлэнд ТУЗ-ын гишүүн Ц.Чанцал, Э.Гэрэлд-Од нар өөрсдийн зардлаар оролцож шувууны дэгдээхэйн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Big ditchman, шувууны тэжээлийн БНХАУ-ын Fanson групп, инкуботорийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч шведийн James way компани, шувууны вакцин үйлдвэрлэгч тарилгын тоног төхөөрөмжийн компани, Дани, Голланд улсын шувууны махны боловсруулалтын үйлдвэрүүдэд компанийн үйл ажиллагааг танилцуулан сурталчилж, хөрөнгө оруулалтын талаар уулзалтууд зохион байгуулсан. Мөн шувууны аж ахуй, шувууны өвчлөл, өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтуудад сууж мэдээллийг авсан. Энэхүү үзэсгэлэн сургалтууд дээр үндэслэн бизнес төлөвлөгөөг өөрчлөх шинэчлэх, тооцооллын ажлууд хийгдэж байна. Бизнес төлөвлөгөөг эдийн засагч нартай хамтран шинэчлэх ажлыг хийж байна. Үүнтэй холбоотой компанийн стратеги төлөвлөгөөг шинэчлэх зайлшгүй шаардлага гарч байна. Стратеги төлөвлөгөөг хийхэд санхүүжилттэй холбоотой төвөгтэй байдал үүсч байгаа. Цаашид компанийн зүгээс санхүүжилтыг шийдэхгүй бол өртөг өндөртэй судалгааны ажил хийгдэнэ. Мөн мэргэжлийн хүмүүсийг оролцуулан судалгаа хийнэ.

1.2 Удирдлагын чадварыг сайжруулах ажлын хүрээнд ТУЗ-ын гишүүн Б.Сэлэнгэ СЭЗДС-д компанийн засаглалын сургалтанд сууж гэрчилгээ авсан. Одоо ТУЗ-ын 9 гишүүн компанийн засаглалын сургалтанд сууж гэрчилгээтэй болсон. ТУЗ-ын гишүүн Ц.Чанцал, Ц.Ганцэцэг нар нь БНХАУ-ын Хөх хотын Zhenda тэжээлийн үйлдвэртэй танилцаж, шувууны аж ахуйн зохион байгуулалт менежментийг судалж Бөхөг ХК зохион байгуулалтын санал ТУЗ-д хүргүүлсэн.

1.5 Хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөг шинэчлэхэд мэргэжлийн байгууллага, иргэн татан оролцуулж байгаа тул санхүүжилт шаардлагатай байна.

1.6 Холбогдох байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллаа. Монголын хөрөнгийн биржээс хураамжийн төлбөрийг барагдуулах тухай шаардлагыг эвлэрэлийн гэрээ байгуулан сар бүр 700000 төгрөг өгч барагдуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийг биелүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, их хэмжээний зээлийн асуудал шийдэгдэхгүй учир **II, III чиглэлийн** асуудал шийдэгдээгүй байна.

#### **IV. Аж ахуйн чиглэлээр**

Бөхөг ХК-ийн нийт барилгад үзлэг хийж, тооллого явуулсан. Улсын архивын газарт албан бичгээр хандан нийт барилгын хөрөнгийн бүртгэлийг авч өөрийн өмчлөлийн хөрөнгийг тогтоосон. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой маргааныг шийдвэрлэх зорилгоор лавлагааг авч, цэвэр бохир усны байгууламж, гал командын байрыг буцааж авах талаар 2018.08.13 өдрийн 18/15 тоот албан бичгээр ХУД-ын 13-р хорооны Засаг даргад, 2018.08.13-ний өдрийн 18/14 тоот албан бичгээр ХУД-ийн Засаг дарга Алдаржавхланд өмч хөрөнгөө буцаан авах талаар мэдэгдэл хүргүүлсэн. Энэхүү объектын талаар хамтран ажиллах хүсэлт ирүүлснийг ТУЗ-д танилцуулан ажилласан.

Мөн гал командын байрны талаар 2018.08.13-ний өдрийн 18/16 тоот албан бичгээр ХУД-ийн онцгой байдлын хэлтсийн аврах гал унтраах 65-р ангид бичгийг хүргүүлсэн боловч одоо болтол хариу илүүлээгүй байна.

Хөрөнгө санхүүжилттэй холбоотой бусад ажлууд биелэгдээгүй болно.

Мөн Бөхөг ХК-ийн газрын кадастарын зургийг дахин хийлгэж баталгаажуулах ажил явагдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.